



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

185 /185/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.11.22

ЦАГ ҮЕ, ҮЙЛ ЯВДАЛ

ХҮНДЭТ ХАРУУЛЫН ДАЙЧИД ТАНГАРГАА ӨРГӨЛӨӨ



2021 оны II ээлжээр хугацаат цэргийн албанд татагдсан Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн дайчид энэ өдөр эр цэргийн тангаргаа өргөлөө. Цэргийн тангараг өргөх эл арга хэмжээнд ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын дарга, бригадын генерал С.Дашзэвэг, тус газрын орлогч дарга, хурандаа Д.Дугаррагчаа,

ЗХЖШ-ын Цэргийн албаны хэлтсийн дарга, хурандаа Н.Лхагвасүрэн, ЭДАХ-ийн дарга, хурандаа Т.Буянбат нарын хүндэт зочид, Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн удирдлага, бие бүрэлдэхүүн оролцлоо. Тус ангид ирсэн хугацаат цэргийн алба хаагчид цэргийн албаны анхан шатны бэлтгэл сургалтдаа бүрэн хамрагдаж дуусаад

ийнхүү эх орондоо үнэнчийн баталгаа болсон цэргийн тангаргаа өргөхөөр эгнэн жагсаж буй нь энэ юм. Сар хүрэхгүй хугацааны өмнө тэд ижий, аавын эрх танхил хөвгүүд байсан бол энэ өдрөөс хойш эх орноо улам ихээр хайрлах сэтгэл тээж зогсоо эх орны хөвгүүд болж буй нь лавтай.

Түүхэнд энэ өдөр

1915 он.

Хятад цэрэг Егүзэр хутагтын хийдийн чиглэлээр Монгол Улсын хилд цөмрөн оров.



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-9	-23

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
39	24

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,852.0	2,854.0
EUR	3,275.0	3,285.0
CNY	445.80	449.80
RUB	38.50	40.00
JPY	24.65	25.23
KRW	2.38	2.46

ЗУРХАЙ

2021.11.22 ДАВАА ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 18/

ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭГ БАЙГУУЛЛАА

"Алсын хараа-2050" урт хугацааны баримт бичигт батлан хамгаалах салбарын хөгжлийн бодлогыг тодорхой заасан байдаг. Үүний нэгэн шалгуур нь мэргэжлийн цэрэгт суурилсан чадварлаг Зэвсэгт хүчинтэй болох томоохон зорилт юм. Харин Зэвсэгт хүчний харьяа нэгтгэл, анги, байгууллагуудын анхан шатны тусгай эмнэлгүүдийн эмийн санг хариуцсан албан тушаалд энэ чиглэлийн, мэргэжлийн эм баригч бус сувилагч нар давхар үүрэг гүйцэтгэж ирсэн дутагдалтай тал байдаг. Тэгвэл энэ асуудлыг шийдэх ажлын хүрээнд ЗХЖШ-ын захиалгаар эм барих эрх бүхий "Эм найруулагч" тусгай дунд мэргэжилтэн бэлтгэхээр Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуультай хамтын ажиллагааны гэрээг үзэглэлээ.

Тус сургалтыг ганц Зэвсэгт хүчин гэлтгүй Төрийн цэргийн болон Хууль сахиулах байгууллагуудын сувилагч, эмнэлгийн ажилтнуудын дунд цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан 1.5 жилийн хугацаанд цахим болон танхимаар зохион байгуулна. Ингэснээр эмнэлгийн бага мэргэжилтнүүдийг тохирсон албан тушаалд томилгоожуулах чухал ач холбогдолтой юм.



ӨВЛИЙН ТЭРГҮҮН ШАРАГЧИН ГАХАЙ САРЫН ЗУРГААН ЦАГААН МЭНГЭТЭЙ ХӨХ НОХОЙ ӨДӨР

Үс засуулбал:

Эд, малын гарлагатай НАРАН УРГАХ, ШИНГЭХ: 08.08-17.08

Барилдлага:

Рашаан Шүтэн барилдлага: Авахуй

Суудал:

Мод

Энэ өдөр нохой, хонь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Эл өдөр насны хүч дэлгэрнэ.

Эм найруулах, угаал үйлдэх, бэр авах, насны авшиг, насны бүтээл хийх зан үйл хийгээд төрөл садан бололцох, худалдаа наймааны үйлнээ сайн болой. Эм найруулах, гэргий авах, элч зарах, эд авахад сайн.

Зүүн нүд татвал хэрүүл, тэмцэл болох, баруун нь бол эд хувцас олох, зүүн чих нь цангинавал зочин ирэх, баруун нь бол гаслан болох, нохой улшвал галзуурах, хэрээ гуаглавал ураг садан эндэх, тагнай загатнавал хэн нэгний үхсэнийг сонсох, бие татвал гэнэт зочин ирэх, хөл татвал үхэл болохыг үзэх болой.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН
368.892 +536

ЭДГЭРСЭН
536,920

НАС БАРСАН
1,858 +8

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН
6433 +110

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ
132

ЭДГЭРСЭН
6177

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол
Нийт: 257,820,862

Эдгэрсэн
Нийт: 232,718,385

Нас барсан
Нийт: 5,167,758

Цахим шууданд

ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНГИЙН НЭГДСЭН ХУРАЛ БОЛЖ



Тусгай хүчний цэргийн нэгтгэл, ангиудын 2021 оны гүйцэтгэлийн тайлангийн хурал Зэвсэгт хүчний 350 дугаар ангийн байрлалд энэ сарын 19-ний өдөр зохион байгуулагдлаа.

Тайлангийн хуралд Тусгай хүчний цэргийн командлагч, бригадын генерал Б.Баатар, Тусгай хүчний цэргийн штабын дарга, хошууч генерал Л.Гансэлэм болон командлалын газар, хэлтсийн дарга нар, Зэвсэгт хүчний 345 дугаар нэгтгэл, 084, 150, 330, 350 дугаар ангийн удирдлагууд оролцлоо. Мөн Зэвсэгт хүчний 331 дүгээр ангийн удирдлагууд цахимаар оролцсон юм.

Тус хурлаар нэгтгэл, ангийн захирагч, орлогч нар 2020-2021 оны сургуулийн жилд хэрэгжүүлсэн үйл ажиллагаагаа дэлгэрэнгүй танилцуулж, тайлангийн хугацаанд гарсан ололт амжилт, алдаа дутагдлаа дүгнэн ярилцлаа. Түүнчлэн тулгамдаж буй асуудлуудаа командлалын удирдлага, газар, хэлтсийн дарга нарт танилцуулж, ирэх онд хэрэгжүүлэх ажлын зорилго, чиглэлээ тодорхойлон нэгдсэн ойлголцолд хүрлээ.

Хурлын төгсгөлд Тусгай хүчний цэргийн командлагч, бригадын генерал Б.Баатар нэгтгэл, ангиудын удирдлагуудад

цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ, 2022 онд Тусгай хүчний цэргийн командлалаас дэвшүүлсэн зорилго, зорилтыг танилцуулж, хариуцсан ажилдаа албан тушаалтан бүр албаны ухамсар, хариуцлагатай хандаж ажиллахыг үүрэг болголоо.

Мөн Зэвсэгт хүчний 350 дугаар ангийн захирагч, хурандаа Ж.Сүх-Очир болон тус ангийн ахлах тогооч, ахлах ахлагч Ц.Алимаа нар Батлан хамгаалах яамны "Хүндэт жуух бичиг"-ээр шагнагдсаныг гардуулан өгсөн юм.

Тусгай хүчний цэргийн командлал

ОФИЦЕР, АХЛАГЧ НАР ОЛОН ТЭМЦЭЭНД ӨНГӨЛЛӨӨ

Зэвсэгт хүчний 234 дүгээр анги

2021-2022 оны сургуулийн жилийн эхэнд ангийн бие бүрэлдэхүүний дунд "Гар бөмбөг"-ийн тэмцээнийг зохион байгууллаа. Тэмцээний I байрт дэслэгч Б.Сугаррагчаа ахлагчтай баг, II байрт ахлагч Л.Манлайбаяр ахлагчтай баг, III байрт дэслэгч Х.Багабанди ахлагчтай баг тус тус шалгарав. Түүнчлэн Булган аймгийн Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран гэр бүлийн өдөрлөгийг зохион байгууллаа. Тус өдөрлөгийн үеэр ГБХЗХГ-ын зарим мэргэжилтэн "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль", "Хүүхдийн хүмүүжил", "Танд хэрэгтэй гэр бүлийн боловсрол" сэдвээр мэдээлэл хийлээ.

Түүнчлэн өдөрлөгийн төгсгөлд алба хаагчдын дунд "Нэг минут-100.000 төгрөг" хөгжөөнт тэмцээнийг зохион байгуулсан бөгөөд I байрт дэслэгч Б.Сумьяабазар, II байрт ахлах ахлагч Т.Түвшинжаргал, III байрт дэслэгч Б.Пүрэвдорж нар шалгарлаа.

Мөн Төрийн захирааны албан хаагчдын өдрийг угтан "Итгэл даах төрийн алба" сарын



аяны хүрээнд Хялганат тосгоны Төрийн байгууллагуудын аварга шалгаруулах "Гар бөмбөг"-ийн тэмцээн зохион байгуулагдлаа. Тус тэмцээнд 6 албан байгууллагын баг тамирчид өрсөлдөж, эмэгтэйчүүдийн төрөлд Улсын тэргүүний "Хараацай" цэцэрлэг, Хялганат тосгоны Захирагчийн ажлын алба, Хялганат тосгоны Спорт цогцолборын баг тамирчид эхний байруудыг эзлэв.

Эргэтэйчүүдийн төрөлд

Зэвсэгт хүчний 234 дүгээр ангийн "Залуус", "Ахмадын золбоо", Онцгой байдлын 50 дугаар ангийн багууд эхний байруудад шалгарлаа.

Мөн Хялганат тосгоны Соёлын төвөөс зохион байгуулсан "Караоке" тэмцээнд ахлагч М.Бат-Эрдэнэ ахлагчтай Зэвсэгт хүчний 234 дүгээр ангийн "Сүлд" хамтлаг амжилттай оролцож тэргүүн байр эзэллээ.

Дэслэгч Ч.ОЮУНЧИМЭГ

"ХАРАХ ӨНЦӨГ ХАНДЛАГААС ШАЛТГААЛНА" СЭДЭВТ СУРГАЛТЫН ХҮРЭЭНД...



Зэвсэгт хүчний 032 дугаар анги

ЗХЖШ-ын даргын тушаалаар батлагдсан "Харах өнцөг хандлагаас шалтгаална" сэдэвт сургалтыг "Хувь хүний хөгжлийн институт"-тай хамтран энэ сарын 17-18-ны өдрүүдэд зохион байгууллаа. Тус институтын сургагч багш Н.Ариунтунгалаг, Э.Мөнх-Амгалан нар дайчдад "Хүний төрөлх зан араншин, темперамент, авьяас билиг, спортын ур чадвар, харилцааны ур чадвар, хамтран ажиллах чадвар, амжилт гаргах салбарууд, ажил мэргэжлийн чиг баримжаа, эрүүл мэнд (донтолт, таргалалт, дотор эрхтэн) зэргийг хурууны хэний тусламжтай оношлон үнэлж сурах талаар мэдээлэл өгөв. Мөн генетик оношилгоог ганцаарчилсан уулзалтын аргаар зохион байгуулсан юм.

Тус сургалтад 2021 оны II ээлжээр хугацаат цэргийн албанд татагдан ирсэн дайчдыг хамруулсан бөгөөд оношилгоонд хугацаат цэргийн алба хаагчид идэвхтэй хамрагдаж, зочин багшийн асуултад нээлттэй чөлөөтэй хариулан, ярилцаж, халуун дулаан уур амьсгал бүрдүүлсэн үр дүнтэй өдрүүд өнгөрлөө.

"ХАРИЛЦАА БА ХАНДЛАГА"

Зэвсэгт хүчний 353 дугаар анги

Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Хувь хүний хөгжлийн институт, "Эерэг тэмүүлэл" ТББ-ын сургагч багш нартай хамтарсан "Харилцаа ба хандлага" сэдэвт сургалтад ангийн бие бүрэлдэхүүн хамрагдлаа.

Тус сургалт нь цэргийн алба хаагчдын хоорондын харилцаа, тэдгээрийн гэр бүлийн уур амьсгал, хандлагад эергээр нөлөөлөх чухал үр дүнтэй сургалт болж өндөрлөлөө. Энэ үеэр тус ангийн хуулийн офицер, ахмад Б.Түвшинтөгс цэргийн алба хаагчдад ээлжит "Цэргийн алба хаагчдын эрх зүйн байдлын тухай хуулийн танилцуулга" сургалтыг зохион байгуулж бие бүрэлдэхүүний хууль, эрх зүйн мэдлэгийн хүрээг тэлсэн юм.



Мөн Налайх дүүргийн Онцгой байдлын газрын Гал унтраах 028 дугаар ангитай хамтран ажиллах төлөвлөгөөний дагуу тус ангийн сургалтын офицер, ахмад Б.Уянга "Ой хээрийн болон объектын түймэр" сэдвээр Зэвсэгт хүчний 353 дугаар ангийн 323 дугаар

дивизионы бие бүрэлдэхүүнд 2 цагийн багтаамжтай танхимын сургалтыг зохион байгууллаа. Энэхүү онолын сургалтыг төлөвлөгөөний дагуу ирэх сард дадлагаар баталгаажуулах юм.

Ахлах дэслэгч Б.ГАНЧУЛУУН

ХӨРӨГ НЭВТРҮҮЛГИЙН ЗУРАГ АВАЛТАД АМЖИЛТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАГДАВ



Зэвсэгт хүчний 014 дүгээр анги

Ангийн Инженер сапёрын тусгай ротын анхны захирагчаар дэвшин томилогдож, хожим инженер сапёрын тусгай хорооны анхны захирагчаар ажиллаж байсан БНМАУ-ын Ардын их хурлын депутат асан, чөлөөнд байгаа хурандаа Я.Цэнджавын тухай хөрөг нэвтрүүлгийн зураг авалтыг энэ сарын 19-ний өдөр Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн байрлалд амжилттай зохион байгууллаа.

Хөрөг нэвтрүүлгийн зураг авалтад Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн захирагчаар ажиллаж байсан бэлтгэл хурандаа Б.Отгонпүрэв, Аж үйлдвэрийн гавьяат ажилтан, бэлтгэл хурандаа С.Сайнцог, ЗХЖШ-ын хэвлэл мэдээллийн албаны дарга, хурандаа Б.Отгонбаяр, Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн захирагч, хурандаа Г.Эрдэнэбаатар, тус ангиас тэтгэвэр, чөлөөнд гарсан ахмадууд болон ангийн нийт бие бүрэлдэхүүн оролцлоо.

Дэслэгч Р.БИЛЭГ

ЭХ ОРОНЧ ҮЗЛИЙГ ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭВ

Зэвсэгт хүчний 256 дугаар анги

"Эх оронч залуу" үндэсний хөтөлбөрийн хүрээнд ЗХЖШ, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, "Эерэг тэмүүлэл" ТББ хамтран улс орон даяар олон талт арга хэмжээг зохион байгуулж байна. Уг ажлын хүрээнд ангийн штабын даргаар ажиллаж байсан бэлтгэл хурандаа Э.Мөнхчулуун ангийн офицер, ахлагч, ажилтан албан хаагчдад "Тусгаар тогтнолын үнэ цэн", цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчдад "Эх оронч үзэл" сэдвүүдээр лекц уншлаа.

Дэслэгч Т.АЛТАНТУУЛ



ШТАБЫН БИЕ БҮРЭЛДЭХҮҮНИЙ "АЛБА СУРТАЛЧЛАХ АЯН" ҮРГЭЛЖИЛСЭЭР



Зэвсэгт хүчний 337 дугаар анги

2021-2022 оны сэтгэл зүйн хангалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу алба салбаруудын үйл ажиллагааг сурталчлан таниулж, хамтын ажиллагааг бэхжүүлэх, бие бүрэлдэхүүний хамт олонч, нөхөрсөг уур амьсгалыг бүрдүүлэх зорилгоор алба сурталчлах аяныг зохион байгуулж

байна. Үүнтэй холбогдуулан бие бүрэлдэхүүний дунд "Цэрэгжлийн буухиа", "Цэнгээнт караоке" тэмцээнүүдийг зохион байгуулав.

"Цэрэгжлийн буухиа" тэмцээнд 9 хүний бүрэлдэхүүнтэй нийт 10 баг авхаалж самбаагаа сорин өрсөлдсөнөөс эхний 3 багийг шалгаруулж, өргөмжлөл, цом, үнэ бүхий зүйлээр, "Цэнгээнт караоке" тэмцээнд 4 хүний бүрэлдэхүүнтэй 9 багийг 3 үе шаттайгаар өрсөлдүүлж эхний 3 багийг шалгаруулж цом, өргөмжлөл, үнэ бүхий зүйлээр шагнаж урамшуулсан юм. Мөн ажил үйлсээрээ хамт олноо тэргүүлэн ажилласан дэслэгч Б.Батмөнх, дэд ахлагч Б.Бат-Эрдэнэ, Н.Насанцэнгэл, Г.Одончимэг, Г.Дүүриймаа нарыг Монголын залуучуудын холбооны "Цэргийн алдар" медалиар шагнав. Түүнчлэн бүтээлч ажлын хүрээнд ангийн шалган нэвтрүүлэх байрны харуул хөнгөний манаанд үүрэг гүйцэтгэдэг бие бүрэлдэхүүний хувцас хэрэглэл дутмаг байсныг шийдвэрлэж өглөө.

Ахлах дэслэгч Д.ЭРДЭНЭСУВД

"ЦУГЛАРАЛТ" ДОХИОГООР АЖИЛЛУУЛЖ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗЛЭГТ ХАМРУУЛАВ

Зэвсэгт хүчний 327 дугаар анги

2021-2022 оны сургуулийн жилийн сургалтын төлөвлөгөөг шат дараатай хэрэгжүүлсээр байна. Өнгөрсөн өдрүүдэд бие бүрэлдэхүүнийг ангийн захирагчийн захирамжийн дагуу "Цугларалт" дохиогоор ажиллуулж, бэлтгэлжилтийн түвшнээ бататгалаа. Тухайлбал, тактик жагсаалын хичээл, сургуулийн будлагын дасгалуудыг боловсруулж, 30 километрийн явган маршийг амжилттай зохион байгуулсан юм. Ингэхдээ бүрэлдэхүүний офицерын 1, ахлагчийн 3 бүлэгт хувааж, хөдөлгөөн үйлдсэн бөгөөд энэ үеэр отолт, хордсон газар орныг туулах ажиллагаа болоод хэргийн байрлалд аранзны хүнсээр хоол хийх үзэргийг гүйцэтгэлээ.

Мөн тус анги энэ сарын 18, 19-ний өдрүүдэд орон нутгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвтэй



хамтран бие бүрэлдэхүүнээ эрүүл мэндийн үзлэгт бүрэн хамрууллаа.

Ахмад Д.ГАНБААТАР